

Монголбанк-нд тайлагнах нь

2021 он 12 сарын 25

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын 2021 оны 4-р улирлын тайлан

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн 2021 оны 4-р улиралд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. 2021 оны 10 сарын 8-нд тайлагнаснаас хойш хугацаанд доорх хурлуудад оролцож ажилласан байна.

2021/10/13 Хувь нийлүүлэгчидтэй зөвлөлдөх хурал (онлайн)

- “Хасбанк болон групп компаниудын бүтцийн өөрчлөн байгуулалтын хувилбарууд” асуудлаар, менежментийн зүгээс хувь нийлүүлэгчидтэй зөвлөлдөх хуралд ажиглагчаар оролцсон.

2021/10/21 ТУЗ-ийн шийдвэр (онлайн)

- ХасБанкны 2021 оны эхний хагас жилийн Ernst&Young Mongolia Audit компаниар хянагдсан санхүүгийн тайланг нягталж, онлайнгаар баталсан.

2021/10/25 ТУЗ-ийн шийдвэр (онлайн)

- ПРО-гийн дараах ХасБанкны бүтцийн өөрчлөн байгуулалтын талаарх менежментээс бэлтгэсэн материалтай танилцан, онлайнгаар баталсан.

2021/10/28 ТУЗ-ийн хурал (онлайн)

- ХасБанкны шинэ компанийн дүрмийн талаар, танилцуулагдсан драфтыг хэлэлцсэн. Миний зүгээс зарим асуулт ба саналуудаа илэрхийлж, зохистой зүйлсийг нь тусгуулах талаар чиглэл өгсөн. Жишээ нь,
 - 6.05 заалт дээр, 5%-аас дээш хувь эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнийг санал болгох эрхтэй талаар, 1-ээс дээш буюу маш олон хүн дэвшүүлэх эрсдэл үүсэх талаар болгоомжлолоо илэрхийлсэн.
 - 7.09 заалт дээр, хувьцааны төлбөрийн хувьд зөвхөн мөнгөөр биш, хувьцаа гэх мэт төлбөрийн хувилбарыг мөн бодолцох шаардлагатайг илэрхийлсэн.
 - 8.06(iv) заалт дээр, хувь нийлүүлэгчээс томилсон гэдгийг, санал болгосон гэж засах талаар.
 - 8.29 заалт дээр, 2/3 нь хараат бус гишүүд байх шаардлагын тухайд, Банк цаашид хараат бус гишүүдээ нилээн нэмэх шаардлага үүсэх тухай.
 - Хувь нийлүүлэгчдийн хурлын тухайд, англи хэл дээр явуулж болох эсэх, хэрэв болох тохиолдолд, монгол ба англи хэл дээр явуулж болох эсэх талаар дүрэм дээрээ тусгах талаар. Мөн ТУЗ-ийн хуралд хэрэглэгдэх хэлний тухайд ч, шаардлагатай бол дүрэм дээр тусгах талаар.

2021/11 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны шийдвэр (онлайн)

- Доорх 2 хүсэлтийг хороогоор хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргасан.
 - СҮҮ ХК-ээс ирсэн, 25 тэрбум төгрөг давсан зээлийн хүсэлт.

- Хувь нийлүүлэгчтэй холбоотой, хувийн кредит карт нээлгүүлэх хүсэлт.

2021/12/07 ТУЗ-ийн Аудитын Хорооны Хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: "Улаанбаатар хотын салбаруудад хийсэн дашбоард-д суурилсан дотоод аудит шалгалтын тайлан", "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны дотоод аудит шалгалтын тайлан", "Дотоод аудитын газрын 2022 оны төлөвлөгөө ба төсөв", "Хамаарал бүхий этгээдүүдийн улирлын тайлан", "Банкны хянан нийцүүлэх улирлын тайлан", "Оны эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн ажлын явц".
- "Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөө ба төсөв"-ийг Аудитын хорооны гишүүд санал нэгтэй баталсан. Миний зүгээс зөрүүтэй байр суурь байгаагүй.
- "Банкны хянан нийцүүлэх улирлын тайлан"-ийг хэлэлцэх явцад, хянан нийцүүлэх албыг одоогоор Эрсдэлийн Удирдлагын захирал хариуцаж байгааг өөрчилж, Гүйцэтгэх захирлын удирдлаган доор зохион байгуулах санал гарч, хороогоор дэмжсэн.

2021/12/07 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: "2021 оны 10 сарын Эрсдэлийн тайлан", "2022 оны төсөв дээр хийсэн стресс тест үнэлгээ", "Муу зээлийн хасалтын (write-off) санал".
- "Муу зээлийн хасалтын (write-off) санал"-ийн тухайд, хэт их хугацаа өнгөрсөн, зээлдэгч нь орлогогүй ба барьцаагүй гэх мэт Банкны зохих журмыг хангасан байсан тул, хорооны гишүүд баталсан.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2021/12/07 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны Хурал (онлайн)

- Ажиглагчаар оролцсон.
- "PSP-ийн оронд нэвтрүүлэх, ажилчдын хувьцааны төлөвлөгөө", "ТУЗ болон хараат бус гишүүдийн цалин хөлс", "ТУЗ-ийн 2022 оны төсөв", "ТУЗ-ийн гишүүдийн дахин сонгууль, сунгах талаар", "IFC-аас томилогдсон гишүүн Melissa Moy Tian ийн үүрэг дуусгавар болж, орны гишүүний томилгооны талаар", "ТУЗ-ийн 2022 оны хурлын төлөвлөгөө" гэсэн сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлэг өрнөсөн.

2021/12/08 ТУЗ-ийн ээлжит хурал (онлайн)

- ТУЗ-ийн хороодын хэлэлцэж баталсан шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - Цалин Урамшууллын Хорооны Хурлаар хэлэлцсэн асуудал дунд, ТУЗ-ийн ердийн гишүүд болон хараат бус гишүүдийн цалин хөлсийг өөрчлөх санал байсан. Миний зүгээс, хараат бус гишүүний цалин хөлсний тухайд, ашиг сонирхлын зөрчил үүсэх тул санал илэрхийлэхгүй гэдгээ хэлсэн. Мөн нийт ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг өөрчлөх саналын тухайд, ТУЗ-ийн гишүүд хэлэлцэж санал гаргах нь өөрөө ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар болгоомжлолоо илэрхийлж, лавлаж асуусан.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “Ковид, эдийн засаг, банкны салбарын 2021 оны 3-р улирлын нөхцөл байдал”, “Банкны үйл ажиллагааны явцын тайлан”, “ХасБанк болон Хас Лизинг компаниудыг нэгтгэх бүтцийн өөрчлөн байгуулалтын явц”, “МонголБанкны дүрмийн сангийн 100 тэрбум төгрөгийн босго шаардлагын талаарх ажлын явц”, “IPO төслийн явц”, “ХасБанкны ХК болох үеийн компанийн шинэ дүрмийн 2 дохь драфт”, “ХасБанкны 2022 оны төсөв”, “Гүйцэтгэх захирлын 2022 оны KPI”, “IT шинэчлэл, дижитал банкны явц”.
 - o “IPO төслийн явц” асуудлын хүрээнд, хөндлөнгийн үнэлгээ хийх компанийг сонгох талаар нилээн нухацтай ярилцаж, нэр хүндтэй, туршлагатай компанийг сонгох талаар санал болгосон.
 - o “ХасБанкны 2022 оны төсөв” хэлэлцэх явцад, 2021 оны үр дүн, санхүүгийн бүх үзүүлэлтүүд маш сайн байгааг хувийн зүгээс онцгойлж сайшаасан. Мөн 2022 оны төсвийн тоон үзүүлэлтүүдийн хувьд, санал нэгтгэйгээр дэмжсэн.

Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

Хүндэтгэсэн,



Б. Уламбаяр

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн